

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

№ 24/12

Улаанбаатар хот

### Хаалттай хүрээнд өрийн хэрэгсэл гаргах тухай

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 995 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмын 1.3 дугаар зүйл, 1.4 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.4 дэх заалт Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ГУЗ”)-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 24/05 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн 2024 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”, Компанийн ГУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор нийт 20,000,000,000 (Хорин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл (цаашид “Өрийн хэрэгсэл”)-ийг хэсэгчлэн (транч) гаргаж санхүүжилт татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Компанийн гаргаж буй Өрийн хэрэгслийг “Монгол Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо ӨЗБ” ГҮТББ-ын зохицуулалтад байх Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлж хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалсугай.
3. Өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралтад зааснаар баталсугай.
4. Өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөлийн хүрээнд, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээ, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан Өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд хэсэгчлэн (транч) гаргах хувь хэмжээ, хэсэгчлэн гаргах хугацаа, хүүгийн хэмжээг тухай бүр нарийвчлан тогтоох эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
5. Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлд Өрийн хэрэгслийг бүртгүүлэх, анхдагч зах зээлд арилжаалахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагаар “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК, “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-иудыг сонгосугай.
6. “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК, “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-иудтай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулах, тус гэрээний дагуу хүлээх мөнгөн хөрөнгийн гүйлгээ, зарцуулалтыг “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК, “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-иудын бүрэн хяналтад байлгах үүргээ биелүүлэх зорилгоор бусад шаардлагатай гэж үзсэн гэрээг тус компаниудтай байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

№ 24/12

Улаанбаатар хот

7. Өрийн хэрэгсэл гарган арилжаалах замаар татан төвлөрүүлэх санхүүжилтийн үүргийн гүйцэтгэл хангуулагчаар “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК, “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-иуд ажиллахыг дурдсугай.
8. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж холбогдох бүхий л баримт бичиг, бусад шаардлагатай гэрээ, хэлцэлд Компанийг төлөөлөн гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
9. Өрийн хэрэгсэл гарган санхүүжилт татан төвлөрүүлэх ажилтай холбогдон гарах аливаа төлбөр, шимтгэл, хураамж, бусад зардлыг холбогдох гэрээ, хууль тогтоомжид заагдсан хугацааны дотор тухай бүр төлөх, Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
10. Өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой ажлын үйл явц, үр дүн болон энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



**ТУЗ-ИЙН ДАРГА**

**О.БОЛДБААТАР**

# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

№ 24/13

Улаанбаатар хот

## Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн үйл ажиллагааны эрэлтийг хангах, үйл ажиллагааны цаашдын өсөлтийг хадгалах, шаардлагатай үед эх үүсвэрийг тухай бүр авч ашиглах зорилгоор толгой компани “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 10,000,000,000 (арван тэрбум) хүртэл төгрөгийн зээлийн шугамыг 20,000,000,000 (хорин тэрбум) хүртэл төгрөг болгон нэмэгдүүлэх хүсэлт гаргасантай танилцаад:

- Компанийн зээлийн багц нь 2023 оны эцсээр 125.4 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 76.4% өссөн, цаашид өсөх боломжтой болохыг харгалзан;
- Компани нь өөрийн зээлийн бүтээгдэхүүний сонголт, төрөлжилтийг нэмэгдүүлж, шинээр “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүн гаргасан бөгөөд тус бүтээгдэхүүнээ зах зээлд үе шаттайгаар нэвтрүүлэхэд эх үүсвэрийн нэмэлт хэрэгцээ байгааг харгалзан;
- Толгой компани “АНД Системс” ХХК-тай байгуулсан гэрээнд зөвхөн үнийн дүнгийн хувьд өөрчлөлт орж буй бөгөөд гэрээний үндсэн нөхцөл нь санхүүгийн зах зээлийн дундаж үнэтэй дүйцэхүйц байгаа болохыг харгалзан;

толгой компани “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.

2. “Санхүүжилтийн гэрээ”-д энэхүү тогтоолоор батлагдсан нөхцөлийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж, гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

№ 24/14

Улаанбаатар хот

## Охин компани үүсгэн байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.13 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.8, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.6.1, 9.6.5, 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зах зээлд шинээр нэвтрүүлж буй “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүнийг жижиг, дунд үйлдвэрлэгчдэд санал болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж тогтвортой санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлэх зорилгын хүрээнд Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар шинэ охин компани (цаашид “Охин компани”) байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Шинээр байгуулах Охин компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 4,000,000,000 (Дөрвөн тэрбум) төгрөг байх бөгөөд нэг бүр нь 1,000,000 (Нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 4,000 (Дөрвөн мянга) ширхэг гаргасан энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.
3. Охин компанийн Хувь нийлүүлсэн хөрөнгийг энэхүү тогтоолын 2-т заасан хэмжээнд, Компанийн 2023 оны цэвэр ашгаас мөнгөн хөрөнгө хэлбэрээр оруулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
4. Охин компани нь эхний ээлжид “мэдээлэл технологийн үйл ажиллагаа” эрхлэх бөгөөд цаашид Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрлийг авсны үндсэн дээр үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг дурдсугай.
5. “ЛэндМН ББСБ” ХК-ийг төлөөлөн Охин компанийн үүсгэн байгуулагчийн эрхийг хэрэгжүүлэх буюу Охин компанийг үүсгэн байгуулах, бүртгүүлэхтэй холбоотойгоор аливаа шийдвэр, тогтоол гаргах, дүрмийг батлах, бүртгүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
6. Охин компани үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэний дараа Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрөл авах хүртэл хугацаанд тус компанид эзэмшиж буй хувьцааны эрх буюу хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхт төлөөлөгчөөр Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-ыг томилсугай.

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр

№ 24/14

Улаанбаатар хот

7. Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
8. Охин компанийг үүсгэн байгуулсны дараа Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгаж, тус үйл ажиллагаатай холбоотой бүхий л баримт бичгийг бэлтгэх, баталгаажуулах эрхийг олгосугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилт, Компанийг төлөөлөн Охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйтай холбоотой аливаа шийдвэр, үйл ажиллагааг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О. БОЛДБААТАР